МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

# ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
ГТБГ-ЫН ДАРГА **Ч.ХИШИГДАЛАЙ**

2026.01.27

# ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬ

**1991**

- **Гэрээний олон хэлбэрийг зөвшөөрсөн;**
- **Төрийн оролцоо хяналт бага;**
- **Хөрөнгө оруулалтыг дэмжсэн;**
- Бүтээгдэхүүн хуваах, Зардал нөхөх;
- Хууль хэрэгжүүлэх журам;
- **Нөөц ашигласны төлбөрийг бүтээгдэхүүн хуваах тооцоонд оруулж болно.**

**2014**

- Төрийн оролцоо нэмэгдсэн;
- **Гадаад, дотоодын хуулийн этгээдүүд ижил тэнцүү эрх, үүрэгтэй;**
- Эрлийн гэрээ;
- **Бүтээгдэхүүн хуваах гэрээ;**
- Тусгай зөвшөөрөл;
- **Уламжлалт бус газрын тос;**
- **Сонгон шалгаруулалт;**
- Төлбөр урамшуулал.

**2026** ▸ **ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА**

## САЛБАРЫН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БУЙ БУСАД ХУУЛЬ

- **2002** Газрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/
- **2005** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль
- **2010** Хөрөнгө оруулалтын тухай хууль
- **2013** Хилийн боомтын тухай хууль
- **2014** Гаалийн тариф, гаалийн татварын тухай, НӨАТ-ын тухай хуулиуд
- **2021** Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хууль
- **2025** Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих тухай хууль

| ӨӨРЧЛӨЛТ | |
|---|---|
| Өөрчлөлт | 40 |
| Нэмэлт | 14 |
| Хүчингүй болгосон *\/зүйл, заалт/* | 1 |

| ДҮН ШИНЖИЛГЭЭ | |
|---|---|
| Давхардал | 13 |
| Зөрчил | 6 |
| Хийдэл | 10 |

# БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ




**1991 оны хуулиар газрын тосны хайгуулын 21 талбайд**

**2014 оны хууль: Газрын тосны хайгуулын 11 талбай, НДМХ 7 талбайд БХГ байгуулсан.**

# ГАЗРЫН ТОСНЫ ХУУЛЬ

| | |
|---|---|
| **ХАЙГУУЛЫН ХУГАЦАА** | |
| Газрын тос | 8+2+2 |
| Уламжлалт бус газрын тос | 10+5 |
| **АШИГЛАЛТЫН ХУГАЦАА** | |
| Газрын тос | 25+5+5 |
| Уламжлалт бус газрын тос | 30+5 |
| **НӨӨЦ АШИГЛАСНЫ /РОЯЛТИ/ ТӨЛБӨР** | |
| Газрын тос | 5-15% |
| Уламжлалт бус | 5-10% |
| **ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР** | |
| Татваргүй | 0% |
| **ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨР** | |
| Хайгуул 1 км$^2$ | \$3, сунгалт \$8 |
| Ашиглалт 1 км$^2$ | \$100, сунгалт \$200 |

| БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ* | ХУВИАР | АМ.ДОЛЛАР |
|---|---|---|
| A. НИЙТ ОЛБОРЛОЛТ | 100% | 100$ |
| B. ГТНАТ /РОЯЛТИ/ | 5%-15% | B=A*(5%-15%) (5$~15$) |
| C. ӨРТӨГ НӨХӨЛТ | 40% | C=(A-B)*40% (34$-38$) |
| D. АШИГТ ТОС | | D=A-B-C (51$~57$) |
| E. ГЭРЭЭЛЭГЧИЙН АШИГТ ТОС | 55% | E=D*55% (31.35$~28.05$) |
| F. ЗАСГИЙН ГАЗРЫН АШИГТ ТОС | 45% | F=D*45% (25.65$~22.95$) |
| T. ЗАСГИЙН ГАЗАРТ НОГДОХ ӨГӨӨЖ/ НИЙТ АШИГ | Take=T/(A-C) (49,44%~57.5%) | T=B+F (30.65~37.95)$ |

* Хайгуулын шатанд дахь 18 БХГ-ний дундаж үзүүлэлтээр тооцов.

# ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

| | |
|---|---|
| **1991** | Газрын тосны тухай хууль |
| **2014** | Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга |
| **2025** | Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл |



# ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

**ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА:**

- Бодлогын уялдааг хангах
- Цаг үеийн нөхцөлтэй уялдуулах
- Ирээдүйн төлөв байдлыг угтсан зохицуулалт

- Газрын тосны тухай хууль /Шинэчлэл/

# ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ АШИГЛАЖ БУЙ
# ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР



# Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

## “АЛСЫН ХАРАА-2050”, МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- ✓ 4.2.16.. “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна.
- ✓ 4.2.7-д “Барилгын материал, мал, амьтны гаралтай болон уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- ✓ 4.2.11-д “Уул уурхайн салбарыг байгальд хал багатай, хариуцлагатай эдийн засгийн салбар болгон хөгжүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

3.6.2-т “Дорноговь аймгийн Алтанширээ суманд газрын тосны бүтээгдэхүүн, химийн үйлдвэрийг бусад дагалдах үйлдвэрийн хамт байгуулна.

## ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

- ✓ 3.3. “Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана.
- ✓ 3.3.1. Газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулж, дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулан нефть-химийн аж үйлдвэрийн суурийг тавих
- ✓ 3.3.2. Газрын тосны ашиглалтын баталгаат нөөцийг өсгөж, газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр хангах дамжуулах хоолойг барьж байгуулах

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

- ✓ 4 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 14 мега төслийн 12-т “Газрын тос боловсруулах цогцолборыг ашиглалтад оруулна. Тус төслийг хэрэгжүүлснээр жилд 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гарган авч, дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах, импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан, уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.
- ✓ 3.3.1.6-д “Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

## ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

- ✓ Давхардал, хийдэл, зөрчлийг арилгах
- ✓ Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- ✓ БХГ болон бусад гэрээний төрлүүдийн боломжийг нээх
- ✓ Төрийн оролцоог бууруулах
- ✓ Уламжлалт бус газрын тосны эрх зүйн орчныг боловсронгуй болгох
- ✓ Хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх
- ✓ Тусгай зөвшөөрөл олголтыг хөнгөвчлөх
- ✓ Төлбөр, хураамж авахгүй байх
- ✓ ӨНЗ-д хийх хяналт, шалгалтын шат дамжлагыг багасгах
- ✓ Төрийн өмчит компанид хайгуул, ашиглалтын талбайг давуу эрхээр олгох

# Практик шаардлага

# МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАНГАМЖ

## ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ, ХЭРЭГЛЭЭ

/мянган.тонн, 2021-2025 он/




## ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ БҮСҮҮДЭЭР




## ГТБ-НИЙ ТӨРӨЛ, ИМПОРТ /хувь, улсаар/







## ГТБ-НИЙ ХУДАЛДАН АВАЛТАД ЗАРЦУУЛСАН ДҮН

/тэрбум.доллар, 2021-2025 он/

| 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|
| $ 1,008 | $ 1,643 | $ 1,632 | $ 1,883 | $ 2,118 |

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ (2025)

**178** ИМПОРТЛОХ

**195** БӨӨНИЙ ХУДАЛДАА ЭРХЛЭХ

**193** ЖИЖИГЛЭНГИЙН ХУДАЛДАА ЭРХЛЭХ

## ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ, ТҮГЭЭХ СТАНЦ



ШАТАХУУНЫ АГУУЛАХ-117

ШАТДАГ ХИЙН АГУУЛАХ-10




ШТС-1,582

АХЦС-122

# ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ




ДАМЖУУЛАХ ХООЛОЙ

**530 км -$ 380 сая**




**БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР**

ДОТООДЫН ГАЗРЫН ТОС 100%
ШУУД АЖЛЫН БАЙР 550

## ҮЙЛДВЭРИЙН ҮНДСЭН ӨГӨГДӨЛ

| | |
|---|---|
| Хүчин чадал: | 1,5 сая тн/жил |
| Боловсруулах тос: | Тосон-Уул XIX & Тамсаг XXI |
| Бүтээгдэхүүний чанар: | MNS & Евро V стандарт |
| Гүн боловсруулалтын технологи: | Гидрокрекинг + Висбрекинг |
| Эрчим хүчний эх үүсвэр: | Үйлдвэрийн ДЦС (35 МВт) |
| Генераторууд: | Нөөцийн дизель 4.8 МВт-ийн дэд станц |

- ТЭЗҮ
- ЗУРАГ ТӨСӨЛ
- ГАЗРЫН ЗӨВШӨӨРӨЛ
- БО-НЫ ҮНЭЛГЭЭ
- САНХҮҮЖИЛТ
- БУСАД ЗӨВШӨӨРӨЛ

# ГЭРЭЭЛЭГЧДЭД ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛҮҮД ТУЛГАРЧ БАЙНА

✓ **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТАГИЙН БАЙГУУЛАГА, ҮАГ-ТАЙ ХОЛБООТОЙ ТӨЛБӨРИЙН АКТ, ШҮҮХИЙН АСУУДАЛ**



Түмэн ойл ХХК - Дорнод аймгийн Засаг даргын шийдвэртэй холбоотой асуудал
Шунхлай энержи ХХК – АҮЭБЯ-тай ТЗ-ийн хугацаатай холбоотой асуудал
Тахь ресурс ХХК – ТББ-тай холбоотой асуудал

ПДТМ, ДГТМ, МАК, Зон Хэн Юу Тиан, ЧГСПЭК, Жи Өү Эйч, Тахь ресурс, Метан газ ресурс, Тэлмэн ресурс зэрэг ААН-үүдийн хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардалтай холбоотой асуудал



Жи Өү Эйч ХХК, Метан газ ресурс ХХК, Тэлмэн ресурс ХХК, Зон Хэн Юу Тиан ХХК -ууд ҮАГ-ын актыг үл зөвшөөрч, шүүхийн асуудал

Петрочайна дачин тамсаг ХХК-д ногдуулсан акт төлбөрийн нийт хэмжээ **550.36** тэрбум төгрөг

Доншен газрын тос /Монгол/ ХХК-д ногдуулсан акт төлбөрийн нийт хэмжээ **27.21 тэрбум төгрөг**

✓ **БАЙГАЛЬ ОРЧНЫ БИЧИГ БАРИМТ БҮРДҮҮЛЭХЭД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ**

**Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ**

**Байгаль орчны менежементийн төлөвлөгөө**

**Багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх**

**/САНАЛ, ТЭМДЭГЛЭЛ/**

**БОНБҮ-ний тухай хууль:**
**8.4. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана:**
**8.4.8 төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл**

# ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТ БУУРЧ БАЙНА.




- 1998-2025 онд 12.033 сая.тонн олборлож, 11.533 сая.тонн экспортлосон.
- Улсын төсөвт 1998-2025 онд нийт ₮2.95 их наяд төвлөрүүлсэн.
- 2025 онд 579 мянган тонн олборлохоос 2025.12.31-ны байдлаар 512,981 тонн газрын тос олборлож, 481,210 тонн газрын тосыг экспортлож ₮231.8 тэрбум төвлөрүүлэв.
- Олборлолтын үйцэтгэл 88.96 хувь, Экспортын гүйцэтгэл 83.34 хувь байна.

## Хөрөнгө оруулалт/4.3 тэрбум ам.доллар/




## Нийт олборлолт/ 11.9 сая тонн/




## Хоногт дундажаар /1650тонн/



# ХАЙГУУЛЫН АЖЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БУУРЧ БАЙНА

## БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ




- ✓ 1991 оны Газрын тосны тухай хуулиар:
  21 БХГ;
  Хөрөнгө оруулалт 1993-2013 он **1621.5 сая$**
- ✓ 2014 онд ГТТХууль шинэчлэгдснээс хойш:
  ГТ-ны -9 талбай, НДМХ 8 талбайд БХГ байгуулсан;
  Хөрөнгө оруулалт 2014-2023 он **89.1 сая$**

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ



# ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН
# ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- Давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;
- Газрын тос, байгалийн хийн баялгийн менежментийн систем (PRMS)-д нийцүүлэн зарим нэр томьёог өөрчлөх, нэмэх;
- Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас ААН-ийн хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх;
- Хайгуулын үе шатанд энэхүү гэрээгээр хөрөнгө оруулагчаас авдаг төлбөр, хураамжийг бууруулах;
- Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ) болон бусад гэрээний дагуу (Татвар-роялтийн гэрээ, Үйлчилгээний гэрээ, Хамтран ажиллах гэрээ, Орлого хуваах гэрээ г.м) явуулах боломжийг нээх;
- БХГ-ний дагуу үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулагчийг хуульд заасан бусад гэрээний төрлүүд рүү шилжих боломжийг олгох;

## ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН

# ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- Уламжлалт бус газрын тос (нүүрсний давхаргын метан хий, шатдаг занар)-ны эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Төрийн өмчит компанид хайгуул, ашиглалтын талбайг давуу эрхээр олгох, Засгийн газраас зөвшөөрөл авсны үндсэн дээр газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг гадаад дотоодын аж ахуйн нэгжтэй хамтран явуулах гэрээ байгуулах;
- Газрын тосны салбарын татварын орчныг тогтворжуулах;

  Хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олголтыг хөнгөвчлөх;
- Өртөг нөхөгдөх зардалд хийх хяналт, шалгалт, баталгаажуулалтын шат дамжлагыг багасгах;
- Татан буулгалтын баталгаа болох мөнгөн хөрөнгийн хувь хэмжээг судалгаанд үндэслэн бууруулах;

# ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- ААН-үүдийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж буй хуулийн зарим зүйл, заалтуудыг хасах, цаг хугацааны хувьд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй асуудлуудыг зохицуулах;
- БХГ-ний загварыг Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн шинэчлэх, бусад гэрээний загварыг батлах;
- Хайгуул, ашиглалтын үе шатанд орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан гэрээг тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сум, дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллах. Уг дэмжлэгийн хэмжээ нь хайгуулын шатанд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн хөрөнгө оруулалтын хэмжээ, ашиглалтын шатанд олборлолтын хэмжээнээс хамаарч тодорхой хувиар тогтоох;
- Нээлттэй талбайд өмнө нь хийгдсэн газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон анхдагч болон үр дүнгийн тайлан, өгөгдөл, судалгааны материалуудыг нээлттэй, ил тод болгох нөхцөлийг бүрдүүлэх;
- БХГ-ний эрх, үүргийг шилжүүлэх нөхцлийг илүү уян хатан болгох;

## ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН
# ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- Аж ахуйн нэгж нь туслан гүйцэтгэгчээ бие даан сонгон шалгаруулах боломжийг олгох;
- Гэрээлэгч нь ЭБМЗ-өөр батлуулсан нөөцөөс олборлолтын үйл ажиллагааг явуулахаар зохицуулах;
- Хайгуулын хугацаанд туршилтын олборлолт хийх, бүтээгдэхүүн борлуулах боломжийг нээх.

# ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНЫ ДАРАА ҮҮСЭЖ БОЛОХ
# НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР, ХҮРЭХ ҮР ДҮН



Газрын тосны хайгуулын төслүүдэд хөрөнгө оруулагчдыг татан оролцуулж олон томоохон ордуудыг шинээр нээн илрүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн таатай, тогтвортой орчин бүрдэнэ.




Дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тасралтгүй, найдвартай хангах нөхцөл бүрдэнэ.



Нүүрсний давхаргын метан хийн эдийн засгийн үр ашигтай нөөц илрүүлснээр эрчим хүчний хараат байдлаас гарч, агаар, орчны бохирдлыг бууруулна.




Монгол Улсын хувьд нэмүү өртөг шингэсэн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинэ салбар бий болох, импортын хараат байдлаас тодорхой хэмжээгээр ангижрах, валютын ханш тогтворжих, газрын тосны бүтээгдэхүүний чанар, үнийн тогтвортой байдал зэрэг нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.



Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс гадна химийн төрөл бүрийн бодис, бүтээгдэхүүн үйлдвэрлэх химийн аж үйлдвэр хөгжих үндэс суурь тавигдана.

# НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИУД

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Газрын төлбөрийн тухай хууль;
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД

# БАЯРЛАЛАА

+976 (51)-263506

info@mmhi.gov.mn

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2,
Засгийн газрын II байрМ

www.mmhi.gov.mn